



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 602

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалт, 2023 оны 467 дугаар тогтоолын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол улсын их сургууль (салбар сургууль)-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 2 нэрийн, нийт 25,500,000.00 (хорин таван сая таван зуун мянган) төгрөгийн балансын үнэ, хурумтлагдсан элэгдэл бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л. Цэдэвсүрэн, Монгол улсын их сургуулийн захирал Д. Бадарч нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.4. Арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д. Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТОРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б. ЦЭНГЭЛ

Д. НАРАНГЭРЭЛ

• 123006535  
31-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны // дугаар сарын -ны өдрийн  
60.2 дугаар тогтоолын хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ХАРЬЯА САЛБАР СУРГУУЛИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,  
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Автомашины нэр, улсын болтон хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуrimтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл ёртөг (төгрөг)	Сэргээн босголтын зардал	Худалдах доод үнэ (төгрөг)	Сургууль
1	Хөюндай старекс, 18-88 ЗАН, КМЖWWH7НР6U695517	2006/2011	15,500,000.00	15,500,000.00	-	-	2,500,000.00	Завхан сургууль
2	Хөюндай старекс, 69-65 ДОР, КМЖWWH7НР6U695518	2001/2016	10,000,000.00	10,000,000.00	-	-	2,000,000.00	Дорнод их сургууль
<b>Нийт дүн</b>			<b>25,500,000.00 (хорин таван сая таван зуун мянган)</b>	<b>25,500,000.00 (хорин таван сая таван зуун мянган)</b>			<b>4,500,000.00 (дөрвөн сая таван зуун мянган)</b>	